**Аймгийн АДХ-ын 8 дахь удаагийн IV чуулганы өмнө**

# Төрөлх хэл бичгээ улам гүнзгий судлан эзэмшие

Бичиг үсэг үүссэн явдал бол хүн төрөлхтний соёлын үүр хаяарч эхэлсэн хэрэг мөн.

Бичиг үсэг бол алсласан хол газар байгаа хүнтэйгээ саналаа солилцох, залгамжлагч хойт үеийнхэндээ гэрээс сургаал, санаа бодлоо үлдээх гол хэрэглүүр юм.

Хэрэв бичиг үсэг бий болоогүйсэн бол хэдэн зуун жилийн өмнө болсон түүхт хэрэг явдал, хэлэгдсэн уран сайхан хэллэгүүдийг одоогийн хүмүүс бүрэн бүтэн мэдэж хойчдоо дамжуулах бололцоо үгүй байхсан. Бичиг үсэг бол ийм л шаардлагаас үүсэн гарсан хэрэг юм.

Алс хол юм уу, олон жилийн дараах хүмүүстээ санаагаа илэрхийлэх аргыг хүн төрөлхтөн аль эрт дээр үеэс эрж хайсаар иржээ. Ийм оролдлого нь их болхи бүдүүлэг байдалтайгаас хэлний авиа, хэлний зүй, үгсийн дүрэм, хөгжмийн бичлэгийг тэмдэглэн илэрхийлэх боловсронгуй бичиг үсэгт хүрч иртэл олон мянган жилийг туулан түмэн бэрхшээлийг даван сайжирсаар иржээ.

Хүмүүс эрт үед бусад этгээдэд санаагаа илэрхийлэхдээ биет зүйл, эд юмс, зэвсэг багаж тэргүүтнийг илгээж байсан байна.

Хэрэв байлдъя гэвэл сум сэлэм, найрамдъя гэвэл эд эдэлхүүн илгээх жишээтэй байжээ.

Энэ нь бичиг үсэг биш боловч бичиг үсэг үүсэхийн анхны урьдчилсан оролдлого юм.

Хүн төрөлхтөн бичиг үсгийн гайхамшигт эрдэнийг бүтээхдээ зураг дүрсийн бичгээс эхлэн утгын бичиг, үет бичиг, авианы бичиг гэх мэтээр бичиг үсгээ улам урагш давшуулсаар ирэв.

Зураг дүрсийн бичиг нь бусдад илэрхийлэх гэсэн зүйлээ зурж үзүүлэх буюу илгээх замаар явж байжээ.

Жишээ нь хүн гэхэд хүний, хаалга гэхэд хаалганы дүрсийг зурж явуулдаг байжээ.

Ийм бичгийн ул мөр одоо ч бий бөгөөд ялангуяа хятад бичигт элбэг тохиолддог.

Зургийн бичиг хамгийн хялбар энгийн бүдүүвч юмыг илэрхийлэхээс биш хийсвэр санааг илэрхийлэхэд бэрхшээлтэй байв.

Хүн төрөлхтөн санаагаа аль болох бүрэн төгс бусдад ойлгомжтой илэрхийлэх бичгийг эрмэлзсээр алгуур аажимдаа хэлний үгийн утгаар санаагаа илэрхийлэх, улмаар хүний авиаг тусгайлан эгшиг, гийгүүлэгч гэж ялгаварлан тэмдэглэх бичигт дамжин хүрч ирэв.

Хүн төрөлхтний анхны бичгүүд нь санаагаа бүрэн төгс илэрхийлэхэд нь хязгаарлашгүй бэрхшээлтэй байсан боловч огт бичиггүй байсан цагаа бодвол хэрэг ажил нь их л хөнгөвчлөгдөж бийсан нь эргэлзээгүй.

Монголчуудын тухайд гэвэл аль 7, 8 дугаар зууны үед бичигтэй байсан гэдэг баримт бишгүй байдаг. Гэхдээ Монголчууд Тюрк, Уйгар, Хятад зэрэг олон бичгийг хэрэглэж байв. Энэ нь Монголчуудын эртнээс наш бичиг үсгийг эрхэмлэн хүндэтгэдэг байсныг үзүүлж байна. Монголчуудын хэрэглэж ирсэн дээрх бичгүүдийн дотроос уйгар бичиг хамгийн удаан хугацаагаар хэрэглэгдсэн ба манай эртний бичиг үсэг уран зохиолын дурсгалын зүйлүүд үйгар бичиг дээр элбэг байдаг.

Уйгар бичиг нь аль тэртээ 13 дугаар зууны үеэс эхлэн одоогийн бичгийг хэрэглэх хүртэл монголчуудын бичиг соёлын хэрэгцээг хангаан улам сайжирсаар иржээ.

Уйгаржин бичгийг монголчуудын хэл аялгуу, авианы онцлогт тохируулан сайжруулах зорилгоор 14 дүгээр зууны үед амьдарч байсан Чойжодсэр 17 дугаар зууны үед байсан Ойрдын зая Намхайжанцан нар нэмэлт засвар хийж байжээ.

Монголчууд бас уйгаржин бичгийн зэрэгцээгээр өөр янзын бичгүүдийг хэрэглэж байв.

1269 онд зохиогдсон дөрвөлжин бичиг, 1680—аад оны үед зохиогдсон соёмбо үсгүүд юм.

Эдгээрээс гадна манж, төвдийн сав, шар бичгүүд мөн тод үсэг, латин бичгүүдийг удаа дараа хэрэглэж байжээ.

Ингэж олон янзын бичиг хэрэглэж ирсэн нь нийгмийн амьдралд нийгмийн янз бүрийн хүчин их нөлөөтэй байснаас болсон хэрэг юм.

Гэвч эдгээр бичиг нь ард түмний бичиг болон удаан хэрэглэгдэж чадаагүй. Харин уйгаржин бичиг л шинэ бичиг хэрэглэх хүртэл үйлчилсэн юм.

Монголчууд олон бичиг хэрэглэж ирсэн боловч уйгаржин бичиг шиг монголын түүх соёлын өвийг арвин ихээр хадгалсан бичиггүй билээ.

Манай эртний түүх уран зохиолын дурсгалууд, дэлхий дахины сонгодог зохиолуудын алдарт орчуулгууд уйгаржин бичиг дээр хадгалагдаж байна.

Энэ нь уйгаржин бичгийг залуучууд сэхээтэн бүр зай завaараа сурвал зохих бичиг гэдгийг харуулна.

Монголчууд ийм олон янзын бичиг сурч хэрэглэж ирсэн нь эртний бичиг соёлтой улс байсныг гэрчилж байна.

«...Өсөхөөс сурсан үндэсний хэл, мартаж болшгүй соёл, үхтэл орших төрөлх нутаг, салж болшгүй орон» гэж манай шинэ үеийн уран зохиолыг үндэслэгчийн нэг Д. Нацагдорж «Миний нутаг» гэдэг алдарт шүлэгтээ шүлэглэжээ.

Энэ нь үндэсний хэл бичгээ эх оронтойгоо адилтган зэрэгцүүлж үзсэн хэрэг юм.

Ер нь эх орондоо хайртай хүн, эх хэл бичигтээ хайртай байх ба бас үндэсний хэл бичгээ хайрлах үзэл бол эх оронч үзэл мөн.

Монголын ард түмэн хэзээнээсээ бичиг үсгийг эрдмийн дээд зүйл гэж үздэг байсан нь манай аман зохиол, зан заншилд тодорхой тусгагдсан байдаг. Тухайлбал «Биеэ мэдэхгүй хүн ухаангүй, бичиг мэдэхгүй хүн эрдэмгүй» гэх мэтийн зүйр цэцэн үгс аль олон байдаг билээ.

Бас бичиг сурахын тус, эрдэм сураагүйн хор холбогдлыг үзүүлсэн явган үлгэрүүдийг манай ард түмэн бишгүй л ярилцдаг билээ. Манай ард түмэн ном бичгийг зөвхөн хадгалагч хүмүүс биш түүнийг аль болохоор сурч судлах, үр хүүхэддээ сурган судлуулахыг эрмэлздэг сайхан заншилтай юм.

Энэ нь манай ард түмэн үндэсний бичиг үсгээ үнэт эрдэнийн санг нээх түлхүүр гэж лавтай мэдэж хайрлан хүндэтгэдэг байсны гэрч мөн.

«Эрийн жолоо зориг, эрдмийн жолоо бичиг» гэж манай ардын цэцэн үг бий.

Үнэхээр үндэснийхээ бичгийг олигтой сайн сурахгүйгээр бусад эрдэм ухааныг эзэмшиж болохгүй. Ер нь төрөлх бичгээ сайн эзэмших явдал нь бусад төрөл бүрийн эрдэм ухааныг эзэмших гол нөхцөл мөн.

Олон төрлийн шинжлэх ухааныг эзэмшиж, эрдэмтэй боловсон хүн болохыг төрөлх хэл бичгээ гүнзгий эзэмших ажлаас эхлэх учиртай.

Ер нь ямар нэгэн улс үндэстний соёлын хөгжилтийг авч үзэхдээ тэр улс үндэстний хүн амын хичнээн хувь нь бичиг мэдэж байна гэдгээр хэмжээлж үздэг. Монголчуудыг анх бичиг үсэгтэй болж байсан үеийг нь соёлын түүхийн үүр хаяарсан үе гэж үзвэл одоо соёлын түүхийн гэгээн нар мандаад байна.

Ер нь төрөлх хэл бичгээ зайлшгүй сайн эзэмших олон талын шаардлагууд байна.

Их Ленин «Бид эрдэм мэдлэггүйгээр социализмыг байгуулж чадахгүй, эрдэм мэдлэгийг номноос олж авна» гэж сургажээ.

Тэгвэл бичиг үсгээ эзэмшихгүйгээр тэр мэдлэгийг номноос хэрхэн олж авах билээ. Бас төрөл бүрийн эрдэм ухааны болоод дэлхий дахины соёлын үнэт эрдэнэ болсон сонгодог уран зохиолууд их олон нэр төрөл дээр өдий төдий хувиар хэвлэгдэн гарч байна.

Бичиг мэдэхгүй бол энэ сайхан үнэт эрдэнэсийн амт шимтийг авч чадахгүйд хүрнэ. Ер нь ертөнцийн гайхамшгийг танин мэдэхийн оньсон түлхүүр болсон номыг төрөлх хэл дээрээ амтархан уншиж байх хичнээн сайхан билээ.

Ингэхээр бичиг үсгээ сайн сурах, улам гүнзгийрүүлэн судлах явдал чухал байна. Зөвхөн уншиж, үгийг зөв бичихээр хэл бичгийн мэдлэгийг хязгаарлаж болохгүй.

Өөрийн санааг бичгээр яруу тодорхой гаргаж сурах, төрөлх хэлнийхээ цэвэр сайхан хэллэг, түүний яруу сайхныг эвдэх болхи муу ажиллагаанаас бол гоомжилж сурах хэрэгтэй.

Цэвэр сайхан зөв бичээд утга санаа нь тодорхой биш байвал ямар олигтой байхсан билээ.

Бидний бичсэн юм утга уялдаа сайтай, цэвэр яруу, товч тодорхой, ойлгомжтой, сонсогч уншигчдын итгэл анхаарлыг татаж чадахуйц байх ёстой.

Нэг үг өгүүлбэрийн илүү дутуу, хойно өмнөө орох нь бага хэрэг, ерөнхий санаагаа гаргавал гүйцэх нь тэр гээд хайш яйш бичсэн зүйлс хэн хүнд бүрэн төгс, зөв сайн ойлгоц өгөхөд бэрхтэй байдаг учир санаагаа илэрхийлэх гэсэн уг зорилгоо биелүүлж чадахгүйд хүрнэ.

Ер нь хэл бичгийн хамгийн гол үүрэг нь бусадтай харилцахад оршино гэдгийг хатуу анхаарч хувийн захидал өргөдлөөс эхлээд сонины мэдээ, өгүүлэл, найруулал зэргийг бичихдээ уншигч сонсогчдод зөв хялбар ойлгогдохоор бичиж, ярьж сурах хэрэгтэй юм.

Зөв сайхан ярьж бичиж байгаа нь хэл бичгийн соёл, түүний яруу сайхныг эзэмшиж байгаа хэрэг мөн.

Бас зөв түргэн шаламгай бичих нь бичиг үсгээ сайн сурч дадлагажсаны шинж мөн боловч хэтэрхий татлан бичиж үгсийн хэлбэр дүрсийг өөрчлөх нь зүйд нийцэхгүй.

Үг, үсгийг цэвэр сайхан бичиж өгүүлбэр дэх үгсгийг зөв журамтай, ойлгомж төгөлдөр найруулж сурах нь их нарийн ажил юм. Үлгэрлэвэл: Үсгийг холбож үг, үгсийг холбож өгүүлбэр бүтээх нь олон өнгийн эрдэнэсийг харшуулан хэлхэж гоёмсог чимэг хийхтэй төсөөтэй юм.

Иймээс энэ нарийн ажлыг эзэмшихийн тулд зөв бичгийн дүрмээс хэтэрч төрөлх хэлний өгүүлбэрийн зүйг улам нягтлан судлах хэрэгтэй.

Мөн гадаад хэлийг амжилттай суралцахад төрөлх хэл бичиг үндэс суурь нь болно.

Ер нь төрөлх хэлнийхээ дүрэм зүйтэй холбохгүйгээр гадаад хэлийг бүрэн сурч, ном зохиолоос баттай ойлгоц олж авч чадахгүй. Ингэхээр төрөлх хэл бичиг бол өөр хэл сурахад дэвсгэр суурь үндэс нь болж өгнө.

Иймээс төрөлх хэл бичиг бол бусад эрдмийн үүдийг нээх түлхүүр болох нь тодорхой байна.

Иймд төрөлх хэл бичгээ нягт нямбай судлаж, түүний яруу сайхан, өвөрмөц чанарыг чадмаг эзэмшин бусад ард түмний хэлийг сурах нь соёлч хүний эрхэм чанар байх ёстой. Иймээс эрдэм мэдлэгийн түлхүүр болсон төрөлх хэл бичгээ улам гүнзгий судлан эзэмших явдал чухал байна.

**Д. Дуламжав**
**Б. Цэрэндаш**

## *Ажил төрлийн семинар*

Саяхан Сөгнөгөр дахь улсын амралтанд Дорноговь, Төв аймаг, Налайх, Улаанбаатар хотын ҮЭ-ийн байгууллагуудаас өөр өөрсдийн тэргүүний идэвхитнүүдийг үнэ төлбөргүйгээр 18 хоног амрааж тус тусын ажил төрлийн баялаг туршлагыг солилцуулж идэвхитэн амрагчдын туршлага солилцох 2 өдрийн семинар хийв.

Семинарыг МҮЭ-ийн Төв Зөвлөлийн зохион зааварлах хэлтсийн ажилтан С.Нямаа удирдав.

Ажил төрлийн семинарт Дорноговь аймгийн хуулийн байгууллагуудын дэргэдэх ҮЭ—ийн хорооны дарга Жамц, Улаанбаатар хотын худалдааны артелийн дэргэдэх ҮЭ-ийн хорооны үйлдвэр олон түмний комиссын дарга Лхагважав, Төв аймгийн Жаргалантын САА-н дэргэдэх ҮЭ-ийн хорооны хөдөлмөр хамгааллын комиссын дарга Чогдон, Гачууртын САА-н саальчин, ҮЭ-ийн салбар хорооны дарга Тулганаа нарын олон арван идэвхитнүүд туршлагаа ярив.

Мөн идэвхитнүүд хүнтэй яаж ажиллах тухай, идэвхитэн бүр ухуулагч байх ёстой гэх зэргийн сэдвүүдээр ажил төрлийн семинар ба маргаан зохиов.

**Ж. Доржготов**

*Орон бүхний пролетари нар нэгдэгтүн*

# Анхдугаар ТАВАН ЖИЛ

*Төв аймгийн намын хороо,*
*А.Д.Х. Гүйцэтгэх захиргааны сонин.*

| 21 дэх жилдээ № 63 (1752) | 1968 ОНЫ 8 ДУГААР САРЫН 26 | ДАВАА |
|---|---|---|

## МХЗЭ—ийн 47 жилийн ой

МАХН—ынхаа удирдлагаар 1921 оны 8 дугаар сарын 25—нд анх 17 гишүүнтэйгээр байгуулагдаж байсан «Бошгыг халах эвлэл» одоо МАХН—ын дайчин туслагч бэлтгэл хүчнийхээ үүргийг нэр төртэй биелүүлж алдар гавъяаны 4 одонгоор аранзал улаан тугаа мялааж эгнээндээ 80 гаруй мянган гишүүдийг хамарсан олон нийтийн томоохон байгууллага боллоо.

МХЗЭ эх орноо харийн дайснаас чөлөөлж ард түмэндээ эрх чөлөө олгож, жаргалант амьдралыг авчрах их хэрэгт ч улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлж улс орноо харанхуй бүдүүлэг байдлаас ангижруулан соёлын хувьсгал хийхэд ч, ангамал талаар ус урсгаж, атар газарт тариа найгуулахад ч ямагт хушуучилж ирлээ.

Одоо манай улсын бүх хүний 60 гаруй хувийг залуучууд, ХАА дахь социалист хөдөлмөрийн хөдөлгөөнд хамрагдагчдын 60 хувийг МХЗЭ—ийн гишүүд эзлэж байна.

Зөвхөн манай аймгийн бүх хүний 55,7 хувийг залуу үеийнхэн эзлэж байгаа бөгөөд бүх эвлэлийн гишүүд залуучуудын 60 шахам хувь нь материаллаг үйлдвэрлэлд ажиллаж байна.

Малыг дулаан хашаа саравчаар хангаж, арвин их тэжээл бэлтгэхэд МХЗЭ—ийн гишүүд, залуучууд ямагт хушуучлан, жил бүр говь усжуулах их аянд залуучууд морддог боллоо.

Залуучуудын гар оролцож ажиллаагүй тийм үйлдвэр аж ахуйн салбар үгүй боллоо.

Манай залуучууд ажиллахын зэрэгцээгээр сурч дунд, дээд боловсрол эзэмшдэг сайхан заншилтай болсон байна.

Сүүлийн жилүүдэд ерөнхий боловсролын 8-10 дугаар ангиудыг төгсөөд өөрсдийн сайн дураар өөрийн орны үйлдвэр, ХАА—н салбаруудад олон арван залуучууд очиж ажиллаад, ажиллахын зэрэгцээгээр сурч дээд болоод дунд сургуулиудыг амжилттай төгсгөдөг болжээ.

Нийслэлийн 18 дугаар сургуулийн 8 дугаар ангийг төгсөөд тус аймгийн «Монгол-Польшийн найрамдал» нэгдэлд өөрсдийн сайн дураар ажилласан 20 гаруй сурагчид нэгдлийн үйлдвэрлэлд ажиллахынхаа зэрэгцээгээр 10 дугаар ангиа амжилттай төгсгөж зохих шатны дээд сургуулиудад орж байна.

Эд нарын жишээгээр тус аймгийн Жаргалантийн 10 жилийн дунд сургуулийн 30 гаруй сурагчид МХЗЭ—ийн илгээлт өвөрлөн захиа даалгаврыг авч Заамар нэгдэлд саальчин,тракторчнаар ажиллаж эхэллээ.

МАХН, МХЗЭ—ийнхээ даалгаврыг нэр төртэй биелүүлж эх орондоо их үйлс бүтээхээс эрхэм зорилтгүй гэдгийг манай залуучууд санан ажиллаж байна.

МХЗЭ 47 жилийн турш МАХН-ынхаа мэргэн жолоодлогоор эх орондоо социализм байгуулах үйлсэд хушуучлахдаа ах дүү Зөвлөлт Холбоот Улс болон ардын ардчилсан бусад орны залуу барилгачид Зөвлөлт, Болгар, Чехословак, Унгар зэрэг орны залуучуудтай мөр зэрэгцэн хамт ажиллаж социалист найрамдлын Дархан хотыг байгуулж байна.

Ингэснээр эх орондоо түлш, эрчим хүчний нэгдсэн комплекц үйлдвэрлэл бий болголоо.

Одоо энэ шинэ залуу хотод оршин суугчдын 35 хувь нь залуучууд байна.

Манай залуус зөвхөн хөдөлмөрийн талбарт гавшгайлаад зогсоггүй урлаг соёл, биеийн тамирын аль ч төрөлд нэрээ дуудуулдаг алдар цуутанг олноор төрүүлдэг боллоо.

Залуус маань МЗО—ны III их наадамд амжилттай бэлтгэж урлагийн төрөл ажил сурлагаар 400 гаруй залуус шалгаран оролцож тэдний дундаас авъяасаараа олон түмэндээ гайхагдаж 187 залуус алт, мөнгө, хүрэл медалиар шагнагдлаа.

Зөвхөн манай аймгийн авъяаслаг залуучууд 9 мөнгө, 3 хүрэл медалийг авсан байна.

Энэ бол манай залуусын авъяас чадал хичнээн их өсч байгааг харуулж байна.

Залуучууд ахмад үеийнхээ ажил амьдралын баялаг туршлагаас ихийг сурч байна.

МХЗЭ—ийн өнгөрсөн 47 жилийн баялаг түүх нь ахмад үеийнхнийхээ үлгэр дууриаллаар эх орондоо социализмын материал техникийн баазыг байгуулж байгаа залуучуудын маань түүх юм.

## СҮҮ СААЛЬ

Заамар сум-нэгдлийн саальчин Нацаг хариуцаж буй үнээнээсээ 7000 литр сүү сааж улсад тушаахаас 8 дугаар сарын 20-ны байдлаар 7790 литр сүү тушаагаад байна.

Үүнээс үзэхэд саальчин Нацаг гуай төлөвлөгөөгөө 1000 литр сүүгээр давуулах бололцоотой болжээ.

## Социализмын эрх ашигт нийцсэн тусламж

Ах дүү Чехословакийн ард түмний социалист байгууламтыг хувьсгалын эсэргүү, дайсагнагч хүчний элдэв оролдлогоос баттай хамгаалахын тулд ЗХУ болон БНБАУ,БНАГУ, БНПАУ, БНУАУ-ын засгийн газрууд Чехословакийн нам төрийн зүтгэлтний хүсэлтийн дагуу зайлшгүй шаардагдаж буй тусламж үзүүлж байгаа нь нийт социалист орны, социалист ололтыг хамгаалах, Европ дахь энх амгалан байдлыг бэхжүүлэх, ах дүү орнуудын интернационалист үүрэг зорилт, энх тайвны эрх ашигт бүрнээ нийцсэн, сайн санааны чухамхүү шудрага, өчүүхэн ч хойшлуулшгүй цаг үеэ олсон арга хэмжээ мөн гэж МАХН-ын гишүүн, жирийн ажилчин эмэгтэй би үзэж байна.

Ер нь ах дүү Чехослвакийн ард түмэнд учирч байгаа аюул занал нь бас социалист лагерийн нийт орон, дэлхий дахины шудрага улс түмний энх амгалан байдалд учирч байгаа аюул занал юм гэж ажилчин бид дүүрэн ухамсарч байна.

Иймээс ах дүү Чехословакийн ард түмэнд үзүүлж байгаа дээрх тусламж нь хэзээнээсээ наш энх тайванд дуртай манай ард түмэн, нийт коммунистуудын сэтгэл санаа, хүсэл эрмэлзлэлтэй бүрэн дүүрэн нийцэж байна.

**МАХН-ын гишүүн, аймгийн Хүнсний үйлдвэрийн ажилчин эмэгтэй**
**Б. Осоржам**

## *Өндөр ургац даллаж байна*

### ХАДЛАНГИЙН ТАЛБАЙГААС

Мөнгөнморьт сумын хадлангийн 30 хэсгийн дотроос 8 дугаар сарын 20-ны байдлаар ажил төрлөөрөө түрүүлж арвин их хадлан авч байгаа хадагч Гомбодорж 81 тонн, Туваан 78 тонн, Цэвээн 71 тонн,Р.Дорж 63 тонн, Р. Рэнцэн 60 тонн өвсийг нэг морин машинаар хадаж хаалт хамгаалалтыг бүрэн хийж социалист уралдааны эхний 5 байрыг эзлэж шагнал авав.

Трактор бригадуудын дотроос Норов ахлагчтай бригад 100 тонн өвс хадаж түрүүллээ.

Сумын төвийн албан газруудад арвин их хадлан авах хөдөлгөөн өрнөж мал эмнэлэг 26 тонн ХБ-ийн анги 23 тонн өвс хадаж албан газруудаас түрүүлж явна.

**А. Гончиг**

* * *

Эрдэнэсант сумын Дамдинсүрэн даргатай 3, Доржпалам даргатай механикжсан бригадууд бусдаасаа илүү сайн ажиллаж байна.

Тус бригадад өвс хадах боох ажил зэрэг хийгдэж одоо 8000 гаруй боодол өвстэй болоод байна.

Тус нэгдлийн зөвлөлөөс энэ жил хадлангийн бүх ажлыг дан мориор гүйцэтгэх болзол зарласныг залуу хадланч Базарваань, Доржддэрэм, Дэмбэрэлсамбуу, Ланс нар хангаж олон залуучуудыг манлайлж явна.

**Я. Мядаг**

* * *

Баянбараат сум хадлангийн явцыг 8 дугаар сарын 16—ны байдлаар дүгнэж сумын төвд хариуцлагатны зөвлөлгөөнийг хийж зөвлөлгөөнд хадлангийн явцын талаар сум—нэгдлийн дарга Чүлтэмсүрэн сонсгол тавьж хэлэлцүүлэн тодорхой заалт шийдвэр гаргав.

Одоо тус сумын Батсүмбэрт гаргасан бригад 500 орчим тонн өвс хадаад байна.

Мөн 3 дугаар бригадын Л. Даш, Хайдав, Дашзэвэг нарын өрхүүд 100-160 кг дарш бэлтгэсэн зэрэг ажлын эхлэлт нилээд байна.

Гэвч энэ ажилд хүн бүрийг оролцуулах явдал хангалтгүй, нийт өрхүүд шимт тэжээл түүх ажлыг хийж байгаа боловч түүнээ зохих ёсоор даршлах тордох ажил хангалтгүй байна.

Иймээс дээрх дутагдлыг даруй засч хадлангийн ажлыг түргэтгэе.

**Ц.Жадамбаа**

* * *

Саяхан Бүрэн сумын намын үүр,АДХГ Захиргааны өргөтгөсөн хурал болж хадлангийн явцыг хэлэлцэн, хадланчдын дунд зарласан уралдааныг дүгнэв.

Уралдаанд Цэндсүрэн ахлагчтай тракторын хэсэг, Цэдэндамба даргатай 1 дүгээр бригад түрүүлж намын үүр, АДХГ Захиргааны «Ургацын далайн эзэн» гэдэг цалинт дарцаг хүлээн авав.

**З. Долгоржав**

## *Заамар, Баяндэлгэрээр*

Баяндэлгэр сумын 1 дүгээр бригадын Цэгмэдийн суурийн хадланчин Должин ахлагчтай бригадын 3 хүн баруун Байдлагт 1 морин машинаар 110-аад га-гаас 1200 гаруй бухал хийж 10 тонн өвс хадаад байна.

Мөн 2 дугаар бригадын Дамдингомбын бригад өөрсдийн гэр бүлийнхний хамт «Дэлбэрэхий» гэдэг газарт хадланд гарч 43 га-гаас 20 тонн өвс хаджээ.

**З.Дорж**

* * *

Заамар сумын МХЗЭ-ийн байгууллагаас оторын 10 суурь, хадлангийн 4 бригадад үйлчлэн сурталчлах бригад гарган 4 хоног ажиллуулж аймгийн намын 14 дүгээр бага хурал, АДХ—ын чуулганы шийдвэрийг сурталчилснаас гадна хадланчдад кино, концерт үзүүлж сонирхуулав.

Мөн сурталчлах бригадынхан 32,4 тонн өвс бухалдаж, нуруулдан, өвөлжөөнд зөөж туслалцсан байна.

* * *

Заамар нэгдлийн бод малын бригадын хадланчид бусдаасаа илүү идэвхтэй ажиллаж байна.

Энэ бригад 320 тонн өвс авах төлөвлөгөөтэйгөөс 120 тонныг аваад байгаагийн дотор морин машинч Базаррагчаа, Чимэдрэгзэн нар бусдыгаа хушуучилж явна.

**Н. Батчулуун**

